



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Үндэсний хорооны ажиллах
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 19 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны ажиллах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны орлогч дарга нарт даалгасугай.

3. Энэ тушаалыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

0024200149

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны даргын 2024 оны 03... дугаар сарын 29-ны өдрийн 25... дугаар тушаалын хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг хэрэгжүүлэгч яам, Засгийн газрын агентлаг, төрийн болон төсөвт байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Үндэсний хорооны эрх, үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Үндэсний хороо үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг баримтална.

1.3. Үндэсний хорооны тогтоол, зөвлөмж, хуралдааны тэмдэглэлийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэмдгээр баталгаажуулна.

Хоёр. Үндэсний хорооны үйл ажиллагаа, зохион байгуулалт

2.1. Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.2. Үндэсний хорооны хуралдаан ээлжит болон ээлжит бус байх бөгөөд хуралдаанд Үндэсний хорооны бүрэлдэхүүн /цаашид “гишүүд” гэх/-ий олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.3. Ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хийнэ. Үндэсний хорооны даргын, эсхүл нийт гишүүдийн олонхын саналаар ээлжит бус хуралдааныг хуралдуулж болно.

2.4. Ээлжит хуралдааны товыг Үндэсний хорооны дарга тогтооно. Нарийн бичгийн дарга нар хуралдаанаар хэлэлцэх асуудал, холбогдох баримт бичгийг хуралдаан товлогдсон өдрөөс ажлын таваас доошгүй өдрийн өмнө, ээлжит бус хуралдаан болох тохиолдолд тухай бүр нь Үндэсний хорооны гишүүдэд хүргүүлнэ.

2.5. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцож чадахгүйн улмаас саналаа бичгээр ирүүлсэн гишүүнийг хуралдааны ирцэд оруулж тооцно.

2.6.Гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой хэрэгжүүлэх чиг үүрэг, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд урьдчилан мэдэгдэж, түдгэлзэж буйгаа хуралдаан даргалагчид мэдэгдэнэ.

2.7.Үндэсний хороо бүрэн эрхийнхээ хүрээнд тогтоол, зөвлөмж (цаашид шийдвэр гэх) гаргах бөгөөд тэдгээрийг Үндэсний хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.8.Хуралдааны тэмдэглэлд Үндэсний хорооны дарга, эсхүл хуралдаан удирдсан Үндэсний хорооны орлогч дарга болон нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна.

2.9.Хуралдаанаас гарсан шийдвэрийг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч болон шаардлагатай тохиолдолд холбогдох бусад байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.

2.10.Үндэсний хорооны даргын эзгүйд түүний үүрэг болгосон Үндэсний хорооны орлогч дарга чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гурав.Үндэсний хорооны эрх, үүрэг

3.1.Үндэсний хороо дараах эрх, үүрэгтэй:

3.1.1.хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.2.хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын үйл ажиллагааны уялдааг хангах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.1.3.хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.1.4.хөтөлбөрт туссан хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсруулах, боловсронгуй болгох үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах;

3.1.5.хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

3.1.6.хуралдаанаас гарсан тогтоол, зөвлөмжийн хэрэгжилтийн үр дүнг Засгийн газарт танилцуулах;

3.1.7.шинжээчдийн баг ажиллуулах;

3.1.8.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Дөрөв.Үндэсний хорооны дарга, гишүүн, нарийн бичгийн даргын эрх, үүрэг

4.1.Үндэсний хорооны дарга дараах эрх, үүрэгтэй:

4.1.1.Үндэсний хорооны үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

4.1.2.Засгийн газрын хуралдааны шийдвэр, Ерөнхий сайдын өгсөн үүрэг болон Үндэсний хорооны шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

4.1.3.хуралдааныг товлон, хэлэлцэх асуудлыг тогтоох, хуралдааны дэг батлах, хуралдаан даргалах;

4.1.4.Үндэсний хорооны орлогч дарга, гишүүдэд үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хянах;

4.1.5.Үндэсний хорооны үйл ажиллагааны тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

4.2.Үндэсний хорооны гишүүд дараах эрх, үүрэгтэй:

4.2.1.хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, явц, үр дүнг хорооны дарга, эсхүл Үндэсний хорооны хуралдаанд тайлагнах;

4.2.2.Үндэсний хорооны шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнг эрхэлсэн салбар, хариуцсан чиг үүргийн хүрээнд гаргаж тайлагнах;

4.2.3.Үндэсний хорооны үйл ажиллагаа, түүний тайлантай танилцах, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах;

4.2.4.хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой судалгаа, тайлан, статистик, бусад мэдээллийг тухай бүр гаргаж өгөх;

4.2.5.Авлигатай тэмцэх газрын хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан нэгжтэй үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээлэл солилцох, дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэшсэн албан хаагчийг томилох;

4.2.6.хуралдаанд тогтмол оролцох, хэлэлцэж байгаа асуудалд санал өгөх;

4.2.7.Хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцүүлэх тохиолдолд холбогдох шийдвэрийн төсөл, материалыг хуралдаан зохион байгуулагдахаас ажлын 10-15 өдрийн өмнө нарийн бичгийн дарга нарт хүргүүлэх;

4.2.8.хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах.

4.3.Үндэсний хорооны нарийн бичгийн дарга нар дараах эрх, үүрэгтэй:

4.3.1.хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө боловсруулж, орлогч дарга нарт танилцуулж, Үндэсний хорооны даргаар батлуулах;

4.3.2.хуралдааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах, хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийн бүрдлийг хангуулах;

4.3.3.хуралдааны явцын тэмдэглэл хөтлөх, албажуулах;

4.3.4.хуралдаанаас гарсан шийдвэрийг албажуулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ажиллах;

4.3.5.хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талууд болон иргэний нийгэм, хувийн хэвшлийн үйл ажиллагааны уялдааг хангах талаар хамтран ажиллах;

4.3.6.хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал боловсруулж, Үндэсний хороонд танилцуулах, шийдвэрлүүлэх;

4.3.7.хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалд санал өгөх;

4.3.8.Үндэсний хорооны шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийн үр дүнг тухай бүр нь Үндэсний хорооны дарга, орлогч дарга, гишүүдэд танилцуулах;

4.3.9.Хуралдааны зохион байгуулалт, дэгтэй холбоотой асуудлаар Үндэсний хорооны дарга, орлогч дарга нарт танилцуулж, чиглэл авах.

Тав. Бусад

5.1.Үндэсний хорооны хуралдаан зохион байгуулах зардлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцах бөгөөд үйл ажиллагаанд холбогдох бусад зардлыг Авлигатай тэмцэх газар хариуцна.

5.2.Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбоотой төрийн болон албаны, хувь хүний нууцад хамаарах асуудлыг задруулахыг, хуралдааны шийдвэр баталгаажих хүртэл аливаа мэдээллийг бусдад тараахыг хориглоно.

5.3.Үндэсний хороо нь тухайн жилийн үйл ажиллагааныхаа тайланг дараа жилийн нэгдүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

5.4.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----